**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЖАРГАЛАНТ СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/8/СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2021 он | Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: Х khovd@audit.gov.mn<br>Аудитын менежер:<br>Утас: 70432545 Цахим хаяг:<br>Тунгалаг бүртгэл Аудит ХХК<br>Аудитор: Ч.Мөнхцоож<br>Утас: 99028555<br>Цахим хаяг:munhuu8555@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга


1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ..... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ..... 4

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН ..... 4

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН ..... 6

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН ..... 8

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ..... 9

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН ..... 10

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН ..... 11

3.Аудитын тайлан ..... 11

3.1. Ерөнхий зүйл ..... 11

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 11

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 12

3.4. Материаллаг байдал ..... 12

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 13

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 14

3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14

3.9. Аудитын илрүүлэлт ..... 15

Залруулсан алдаа ..... 15

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 15

Аудитын зөвлөмж ..... 15

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд: ..... 15

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ ..... 15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 16

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/114
танай ______ -ны № ______ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ш.ЧАНЦАЛХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсрол олголтын үр дүн, хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

021020367

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,868,590.00** | **20,135,555.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 8,314.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 8,314.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 8,314.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 8,314.00 |
| **33** | **АВЛАГА** | 117,830.00 | 663,854.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 117,830.00 | 663,854.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 17,750,760.00 | 19,463,387.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | 953,000.00 |
| 35130 | Эм боох материал | - | 953,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 17,750,760.00 | 18,510,387.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,214,310.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,980,960.00 | 471,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,555,490.00 | 18,038,486.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **371,988,576.13** | **359,057,020.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 371,988,576.13 | 359,057,020.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 307,364,701.11 | 294,547,395.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 312,851,481.20 | 312,851,481.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (20,282,701.72) | (33,443,977.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 32,017,870.00 | 35,516,870.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (25,921,231.16) | (27,425,995.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,836,080.40 | 28,836,080.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (20,136,797.61) | (21,787,062.45) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 64,623,875.02 | 64,509,625.06 |
| 39301 | Програм хангамж | 594,500.00 | 594,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (194,624.98) | (308,874.94) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 64,224,000.00 | 64,224,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **389,857,166.13** | **379,192,575.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **132,654.00** | **8,314.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 132,654.00 | 8,314.00 |
| **413** | **Өглөг** | 132,654.00 | 8,314.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 8,314.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 132,654.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 132,654.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **389,724,512.13** | **379,184,260.33** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 389,724,512.13 | 379,184,260.33 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 246,033,202.00 | 246,033,202.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 246,033,202.00 | 246,033,202.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (174,526,656.85) | (185,066,908.65) |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (174,526,656.85) | (174,526,656.85) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (10,540,251.80) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 318,217,966.98 | 318,217,966.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** VI=IV+V | **389,857,166.13** | **379,192,575.33** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **318,590,981.15** | **344,860,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,355,181.15** | **3,499,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,355,181.15 | 3,499,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,355,181.15 | 3,499,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 10,355,181.15 | 3,499,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,235,800.00** | **341,361,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 270,098,600.00 | 303,385,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 270,098,600.00 | 303,385,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,120,000.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 120,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 34,017,200.00 | 37,976,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,017,200.00 | 37,976,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **322,325,782.18** | **355,401,151.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **322,325,782.18** | **355,401,151.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 322,325,782.18 | 338,666,143.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 200,185,821.29 | 237,414,002.00 |
| 210101 | Үндсэн цалин | 139,064,655.00 | 172,291,402.00 |
| 210102 | Нэмэгдэл | 48,874,066.29 | 63,104,300.00 |
| 210104 | Урамшуулал | 12,247,100.00 | 2,018,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,869,914.71 | 28,750,383.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,059,122.02 | 19,267,583.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,006,955.09 | 2,370,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,595,324.26 | 1,896,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 382,591.88 | 474,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,825,921.46 | 4,741,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,384,200.00 | 32,719,944.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,334,400.00 | 2,442,227.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,854,500.00 | 19,874,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,195,300.00 | 10,403,467.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,482,359.00 | 813,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 352,300.00 | 174,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 71,900.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 85,600.00 | 209,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 34,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 270,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 935,559.00 | 160,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,456,104.00 | 17,486,010.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 418,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,920,064.00 | 17,068,010.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 536,040.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 243,000.00 | 1,606,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 243,000.00 | 1,606,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 109,200.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 109,200.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 320,000.00 | 862,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 320,000.00 | 430,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 432,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,275,183.18 | 19,014,404.51 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,244,902.00 | 2,583,848.71 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,859,127.18 | 16,430,555.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 16,735,008.06 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 16,735,008.06 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 16,735,008.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(3,734,801.03)** | **(10,540,251.80)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,734,801.03)** | **(10,540,251.80)** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **308,355,800.00** | **341,361,900.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,355,800.00** | **341,361,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 270,098,600.00 | 303,385,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 270,098,600.00 | 303,385,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,240,000.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 240,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 34,017,200.00 | 37,976,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,017,200.00 | 37,976,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **308,292,300.00** | **341,353,586.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **308,292,300.00** | **341,353,586.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **308,292,300.00** | **324,618,577.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 199,367,725.00 | 237,414,002.00 |
| 210101 | Үндсэн цалин | 155,206,925.00 | 172,291,402.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,913,700.00 | 63,104,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,018,300.00 |
| 210104 | Урамшуулал | 12,247,100.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,329,675.00 | 29,414,239.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,914,975.00 | 19,931,439.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,853,700.00 | 2,370,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,482,900.00 | 1,896,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370,800.00 | 474,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,707,300.00 | 4,741,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,307,325.00 | 32,719,944.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,334,400.00 | 2,442,227.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,777,625.00 | 19,874,250.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,195,300.00 | 10,403,467.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,319,750.00 | 3,652,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 350,000.00 | 174,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 442,875.00 | 174,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 434,200.00 | 209,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 270,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,092,675.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 2,825,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,975,984.00 | 16,929,950.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 1,371,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,024,994.00 | 15,558,950.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 950,990.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,606,400.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,606,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 80,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 80,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 862,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 430,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 432,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,911,841.00 | 2,020,042.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,855,341.00 | 1,808,448.87 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 56,500.00 | 211,594.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **16,735,008.06** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 16,735,008.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 16,735,008.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **63,500.00** | **8,314.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 63,500.00 | 8,314.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 8,314.00 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 246,033,202.00 | 318,217,966.98 | (170,791,855.82) | | 393,459,313.16 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **246,033,202.00** | **318,217,966.98** | **(170,791,855.82)** | **-** | 393,459,313.16 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (3,734,801.03) | | (3,734,801.03) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **246,033,202.00** | **318,217,966.98** | **(174,526,656.85)** | **-** | 389,724,512.13 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **246,033,202.00** | **318,217,966.98** | **(174,526,656.85)** | **-** | 389,724,512.13 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **246,033,202.00** | **318,217,966.98** | **(174,526,656.85)** | **-** | 389,724,512.13 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (10,540,251.80) | | (10,540,251.80) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **246,033,202.00** | **318,217,966.98** | **(185,066,908.65)** | **-** | 379,184,260.33 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 341,361,900 | 324,618,578 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 341,361,900 | 324,618,578 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 341,361,900 | 324,618,578 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 237,066,100 | 237,414,002 |
| 210101 | Үндсэн цалин | 153,939,400 | 154,295,616 |
| 210102 | Нэмэгдэл | 63,104,300 | 63,104,300 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,018,300 | 2,018,300 |
| 210104 | Урамшуулал | 18,004,100 | 17,995,786 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,004,000 | 29,414,239 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,521,200 | 21,999,539 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,370,700 | 1,853,700 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,896,600 | 1,482,900 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 474,100 | 370,800 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,741,400 | 3,707,300 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,369,700 | 32,719,944 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,333,700 | 2,442,227 |
| 210302 | Түлш, халаалт | 21,877,200 | 19,874,250 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,158,800 | 10,403,467 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 536,800 | 3,652,000 |
| 210401 | Бичиг хэрэг | 105,400 | 174,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 92,600 | 174,000 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 86,600 | 209,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,200 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 270,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 192,000 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 2,825,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 32,077,500 | 16,929,950 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,781,500 | 1,371,000 |
| 210502 | Хоол, хүнс | 29,381,400 | 15,558,950 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 914,600 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,606,400 | 1,606,400 |
| 210604 | Урсгал засвар | 1,606,400 | 1,606,400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 109,200 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 109,200 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 575,600 | 862,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,600 | 430,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000 | 432,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,016,600 | 2,020,043 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,808,449 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,016,600 | 211,594 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 341,361,900 | 324,626,892 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 303,385,800 | 286,650,792 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 303,385,800 | 286,650,792 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 37,976,100 | 37,976,100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 37,976,100 | 37,976,100 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **8,314** |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэмэлт санхүүжилт байхгүй байна.

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ш.Чанцалхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зардлыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, цалингийн тооцооллыг хийхдээ холбогдох журмыг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-наас 2021 оны 02 дугаар сарын 1–ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцоож хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багш бүр хичээл сургалтыг чанартай зааж, эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тоглоомоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэхийг үндсэн зорилгоо болгон ажиллажээ.

2020 оны хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл, баг хамт олны бэлтгэлийг чанар үр дүнтэйгээр зохион байгуулж өдөр тутмын хичээл сургалт, хүүхэд

хөгжүүлэлтийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж зорилтын дор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагаанд багшийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн"Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд ажлын байрандаа хөгжих, чадваржих боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болох, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэн, "Авьяас", "Номын гэгээ", "Хүүхэд бүр цэцэрлэгт" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин ажиллах гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ''бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай''
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ''Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот ''Хоолны зардлын норматив тогтоох тухай''

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт,дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах х арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Бага " гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 338666,1 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 3386,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10664,6 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал дансны үлдэгдэл 1712,6 мянган төгрөгөөр өсөж үндсэн хөрөнгө данс 12931,5 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 8,314 | 8,314 |
| Авлага | 117,830 | 663,854 | 546,024 |
| Бараа материал | 17,750,760 | 19,463,386 | 1,712,626 |
| Үндсэн хөрөнгө | 371,988,576 | 359,057,020 | (12,931,556) |
| **Нийт хөрөнгө** | **389,857,166** | **379,192,574** | **(10,664,592)** |
| Өр төлбөр | 132,654 | 8,314 | (124,340) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 389,724,512 | 379,184,260 | (10,540,252) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **389,857,166** | **379,192,574** | **(10,664,592)** |

Мөнгөн хөрөнгө, авлага дансны үлдэгдэл 554,3 мянган төгрөгөөр өссөн НДШ-н авлага 546,0 мянган төгрөгөөр өссөн нь даатгуулагчийн кодын өөрчлөлтөөс хамаарчээ.

Бараа материал данс 1712,6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ариутгах бодис маск, хамгаалах хувцас зэргийн үлдэгдэл 953,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон утаанаас хамгаалах зориулалтаар 2825,0 мянган төгрөгийн үнэ бүхий 25 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасантай холбоотой байна.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2 ширхэг 3499,0 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютерыг хүлээн авч бүртгэн тайланд тусгажээ.

Үндсэн хөрөнгө данс дээрх 3499,0 мянган төгрөгөөр өсөж тайлант хугацааны элэгдлийн зардал 16430,5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | өмнөх оны | тайлант оны | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт | 270,098,600 | 303,385,800 | 33,287,200 |
| Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт | 34,017,200 | 37,976,100 | 3,958,900 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө | 10,355,181 | 3,499,000 | (6,856,181) |
| Хандив бусад тусламж | 4,120,000 | | (4,120,000) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **318,590,981** | **344,860,900** | **26,269,919** |

Жаргалант сумын 6 дугаар цэцэрлэгийн нийт орлого өмнөх оноос 26269,9 мянган төгрөгөөр буюу 8,2 хувиар өссөн байна. Улсын төсвийн санхүүжилт нь 1 эмчийн орон тоо нэмэгдсэн болон Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл

хийгдсэнтэй, харин орон нутгийн төсвийн санхүүжилт цэвэр бохир усны төлбөр нэмэгдсэнтэй холбоотой өсжээ.

Хүснэгт 3 зардлын үзүүлэлтүүд

Нийт зардал өмнөх оноос 45145,2 мянган төгрөгөөр буюу 11,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 55003,2, бусад урсгал зардал 9857,9 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа 1 сараар хойшилсон, цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 440188,1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 440188,1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43196,1 мянган төгрөгөөр бууруулж 396992,0 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 396992,0 мянган төгрөгийн төсөв батлалснаас улсын төсвөөс 347398,1 орон нутгийн төсвөөс 49593,9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 347398,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 49593,9 мянган төгрөг, нийт 396992,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 379227,2 мянган төгрөгийг зарцуулж 17764,8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зардлыг зардлын зүйл анги хооронд гүйлгэн зарцуулсан, ХХОАТ суутгаагүй зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн уг

зөвлөмжийн хэрэгжилт 90 орчим хувьтай байна. Тайлангийн хугацаанд зарим зардлууд бодитойгоор тайланд тусгагдаагүй байна.

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18810,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16735,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2075,0 мянган төгрөгийг алдаанд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого талд төсөв буцаан төвлөрүүлсэн 16735,0 мянган төгрөг бүртгэгдсэнээс мөн дүнгээр зардал илүү тайлагнасан,

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 2075 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин тооцоолж данс бүртгэлд залруулах алдааг дахин давтахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

Ажиллагсадад олгосон цалин нэмэгдлийг тооцох аргачлалыг баримтлаагүйгээс 1233,8 төгрөгийг илүү, 841,1 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: нийт 2075,0 мянган төгрөгийн алдааг засах зөвлөмж өгөв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

- Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 380.0 мянган төгрөгийн маскийг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал.**

1.1. **Илрүүлэлт:** Ажиллагсдад олгосон цалин, нэмэгдлийн тооцооллыг хийхдээ тухайн нэмэгдлийг тооцож олгох журмыг сайтар судлаагүйгээс ажилласан хугацаанд олгох цалингаас тооцох нэмэгдэл үндсэн цалингаас тооцогдсон хувь хэмжээг тушаал шийдвэрийг дагуу тооцоогүйгээс 1233,8 төгрөгийг илүү, 841,1 мянган төгрөгийг дутуу олгосон зөрчил илэрлээ.

1.2. **Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах гэсэн заалтыг мөрдөж ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар**: Зөвшөөрч байна.

Й3.1. **Илрүүлэлт**: Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

**Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн/ мян.төг/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Ажиллагсдад олгосон цалин, нэмэгдлийн тооцооллыг хийхдээ тухайн нэмэгдлийг тооцож олгох журмыг сайтар судлаагүйгээс ажилласан хугацаанд ногдох цалингаас тооцох нэмэгдэл үндсэн цалингаас тооцогдсон хувь хэмжээг тушаал шийдвэрийг дагуу тооцоогүйгээс | 2075.0 | Зөвлөмж | 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч | Ш.Чанцалхүү Б. Анхзаяа |
| | Зөвлөмжийн дүн | 2075.0 | | | |
| 2 | Төсөвт буцаан төвлөрүүлсэн дүнг зардалд биш орлогод бүртгэсэн | 16735.0 | залруулга | 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч | Ш.Чанцалхүү Б.Анхзаяа |
| | залруулга дүн | **16735.0** | | | |
| | НИЙТ ДҮН | 18810.0 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**